

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/244-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a></p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14-15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15-16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16-17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17-18
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	20-22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага
МЭИК	Монгол эм импекс концерн
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн Хөрөнгө оруулалт
СББ ХХК	Спирт бал бурам Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/244-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>118,593,506.00</u></b>	<b><u>61,838,640.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	62,196,337.00	42,718,471.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	62,196,337.00	42,718,471.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	56,397,169.00	19,120,169.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,287,500.00	7,287,500.00
35110	Тусгай зориулалттай материал	1,520,000.00	1,520,000.00
35130	Эм боох материал	5,767,500.00	5,767,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,109,669.00	11,832,669.00
35410	Бичиг хэргийн материал	37,584,649.00	394,649.00
35420	Аж ахуйн материал	11,085,020.00	10,998,020.00
35450	Барилгын засварын материал	440,000.00	440,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>678,090,914.96</u></b>	<b><u>667,563,831.71</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	678,090,914.96	667,563,831.71
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	414,636,208.95	417,412,491.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	67,225,200.00	120,598,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,640,074.77)	(26,760,494.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	220,575,880.00	216,505,880.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,353,657.95)	(144,116,991.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	355,637,533.73	390,089,459.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(161,883,977.60)	(198,090,902.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	157,631,990.62	157,631,990.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(118,091,445.08)	(125,955,209.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	23,528,700.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	38,553,500.00	-
39217	Ном	3,981,260.00	3,981,260.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	263,454,706.01	250,151,340.00
39301	Программ хангамж	7,479,711.40	7,479,711.40
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,342,205.39)	(7,479,711.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	263,317,200.00	263,317,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,165,860.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>796,684,420.96</u></b>	<b><u>729,402,471.71</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,615,998.00</u></b>	<b><u>44,709,679.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,615,998.00	44,709,679.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,615,998.00	44,709,679.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,615,998.00	44,709,679.00
41361	Байгууллагад төлөх өглөг	913,000.00	39,575,671.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,702,998.00	5,134,008.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>793,068,422.96</u></b>	<b><u>684,692,792.71</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	793,068,422.96	684,692,792.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	140,566,428.00	140,566,428.00

**Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

51101	Өмч: - төрийн	140,566,428.00	140,566,428.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>588,401,929.96</b>	<b>480,026,299.71</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	588,401,929.96	588,401,929.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	(108,375,630.25)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,100,065.00	64,100,065.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>796,684,420.96</u></b>	<b><u>729,402,471.71</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,835,187,470.80</b>	<b>15,292,893,247.36</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,353,488,545.80</b>	<b>11,067,594,819.36</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,353,488,545.80</b>	<b>11,067,594,819.36</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,870,000.00	3,910,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,870,000.00	3,910,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,481,698,925.00</b>	<b>4,225,298,428.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,931,249,000.00</b>	<b>2,482,713,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,931,249,000.00	2,482,213,900.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	500,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>550,449,925.00</b>	<b>1,742,584,528.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,374,275.00	92,709,245.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,200,550.00	12,950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489,805,100.00	1,545,607,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,000.00	91,317,583.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,570,801,254.44</b>	<b>15,401,268,877.61</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,570,801,254.44</b>	<b>15,401,268,877.61</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,546,499,930.80</b>	<b>12,063,794,794.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>592,339,323.00</b>	<b>547,233,626.80</b>
210101	Үндсэн цалин	460,233,833.00	307,615,038.00
210102	Нэмэгдэл	76,315,388.00	175,157,664.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,666,252.00	25,261,067.80
210104	Урамшуулал	27,123,850.00	39,199,856.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,887,768.36</b>	<b>56,208,813.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,405,288.99	40,439,951.37
210202	Тэтгэмжийн даатгал	3,128,966.52	3,938,765.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,046,236.25	3,475,111.06
210204	Ажилгүйдлийн даатгал	718,069.60	749,362.05
210205	Эрүүл мэндийн даатгал	6,589,207.00	7,605,623.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,996,553.00</b>	<b>6,423,435.00</b>
210302	Түлш, халаалт	4,996,553.00	6,423,435.00

**Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	64,475,466.00	65,307,766.00
210401	Бичиг хэрэг	42,350,964.00	41,752,838.00
210402	Тээвэр, шатахуун	13,968,340.00	16,863,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,657,062.00	6,194,888.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	499,100.00	496,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,441,140,545.80	11,025,403,043.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,439,804,545.80	11,024,351,643.36
210502	Хоол, хүнс	-	550,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,336,000.00	501,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,300,400.00	98,310,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,327,500.00	2,940,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,172,600.00	4,613,100.00
210604	Урсгал засвар	19,800,300.00	90,757,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,532,560.00	12,313,900.00
210702	Дотоод албан томилолт	7,532,560.00	12,313,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,389,010.00	7,266,236.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,845,750.00	4,043,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,092,200.00	2,092,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,560.00	299,756.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	808,500.00	753,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	356,438,304.64	245,327,874.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,589,433.00	161,861,465.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,425,000.00	138,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,423,871.64	83,327,809.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,024,301,323.64	3,337,474,083.20
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	924,955,235.00	3,034,627,205.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	543,365,235.00	460,594,649.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	381,090,000.00	1,195,432,556.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,378,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	99,346,088.64	302,846,878.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,346,088.64	232,046,878.20
213304	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	70,800,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>264,386,216.36</b>	<b>(108,375,630.25)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>264,386,216.36</b>	<b>(108,375,630.25)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b><u>2,486,008,925.00</u></b>	<b><u>4,291,404,765.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,310,000.00</b>	<b>3,910,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,310,000.00	3,910,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	4,310,000.00	3,910,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,310,000.00	3,910,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,481,698,925.00</b>	<b>4,287,494,765.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,931,249,000.00	2,482,713,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,931,249,000.00	2,482,213,900.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	500,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	550,449,925.00	1,804,780,865.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,374,275.00	92,709,245.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,200,550.00	12,950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489,805,100.00	1,545,607,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,000.00	153,513,920.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,455,719,625.00</u></b>	<b><u>4,291,104,765.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,455,719,625.00</b>	<b>4,291,104,765.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,369,221,964.36</b>	<b>916,412,210.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	592,400,544.00	547,233,626.80
210101	Үндсэн цалин	421,457,312.00	299,867,054.00
210102	Нэмэгдэл	115,011,796.00	180,430,648.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,807,586.00	27,736,067.80
210104	Урамшуулал	27,123,850.00	39,199,856.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,826,547.36	56,208,813.00
210201	Тэтгэврийн даатгал	31,752,595.48	39,231,086.41
210202	Тэтгэмжийн даатгал	3,128,966.52	4,285,465.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,046,236.25	3,475,111.06
210204	Ажилгүйдлийн даатгал	718,069.60	837,331.79
210205	Эрүүл мэндийн даатгал	7,180,679.51	8,379,818.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,996,553.00	6,423,435.00
210302	Түлш, халаалт	4,996,553.00	6,423,435.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,122,555.00	28,802,666.00
210401	Бичиг хэрэг	2,584,350.00	3,390,280.00
210402	Тээвэр, шатахуун	12,845,123.00	17,336,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,832,432.00	7,579,346.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	860,650.00	496,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	357,283,200.00	72,965,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	356,483,200.00	71,913,700.00

**Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210502	Хоол, хүнс	-	550,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	501,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,998,700.00</b>	<b>59,756,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,020,000.00	2,940,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	4,608,600.00
210604	Урсгал засвар	18,270,100.00	52,208,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,532,560.00</b>	<b>12,482,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,532,560.00	12,482,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,297,010.00</b>	<b>7,439,286.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,753,750.00	4,216,830.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,092,200.00	2,092,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,560.00	299,756.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	808,500.00	753,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>303,764,295.00</b>	<b>125,099,784.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,339,295.00	124,961,184.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,425,000.00	138,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,086,497,660.64</b>	<b>3,374,692,554.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>924,955,235.00</b>	<b>3,029,127,205.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	543,365,235.00	460,094,649.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	381,090,000.00	1,195,432,556.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,373,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>161,542,425.64</b>	<b>345,565,349.20</b>
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	62,196,337.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,346,088.64	232,546,878.20
213304	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	113,018,471.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>30,289,300.00</u></b>	<b><u>300,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,289,300.00</b>	<b>300,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,289,300.00</b>	<b>300,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>30,289,300.00</b>	<b>300,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,289,300.00	300,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(30,289,300.00)</u></b>	<b><u>(300,000.00)</u></b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>140,566,428.00</b>	<b>64,100,065.00</b>	<b>588,401,929.96</b>	793,068,422.96
D01	<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>140,566,428.00</b>	<b>64,100,065.00</b>	<b>588,401,929.96</b>	793,068,422.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>140,566,428.00</b>	<b>64,100,065.00</b>	<b>588,401,929.96</b>	793,068,422.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(69,822,130.25)	(69,822,130.25)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>140,566,428.00</b>	<b>64,100,065.00</b>	<b>518,579,799.71</b>	723,246,292.71

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,546,713,900.00	2,254,077,021.80	292,636,878.20	88.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,546,713,900.00	2,254,077,021.80	292,636,878.20	88.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	655,142,900.00	597,599,816.80	57,543,083.20	91.2
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	461,723,300.00	432,602,496.80	29,120,803.20	93.7
210101	Үндсэн цалин	304,941,900.00	264,149,907.00	40,791,993.00	86.6
210102	Нэмэгдэл	72,925,100.00	107,966,665.60	(35,041,565.60)	148.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	27,736,067.80	10,378,932.20	72.8
210104	Урамшуулал	45,741,300.00	32,749,856.40	12,991,443.60	71.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,332,600.00	56,208,813.00	6,123,787.00	90.2
210201	Тэтгэврийн даатгал	43,863,700.00	39,231,086.41	4,632,613.59	89.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,617,200.00	4,285,465.40	331,734.60	92.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,693,800.00	3,475,111.06	218,688.94	94.1
210204	Ажилгүйдлийн даатгал	923,400.00	837,331.79	86,068.21	90.7
210205	Эрүүл мэндийн даатгал	9,234,500.00	8,379,818.34	854,681.66	90.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,922,000.00	6,423,435.00	498,565.00	92.8
210302	Түлш, халаалт	6,922,000.00	6,423,435.00	498,565.00	92.8
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,271,000.00	24,278,866.00	7,992,134.00	75.2
210401	Бичиг хэрэг	4,039,200.00	3,320,280.00	718,920.00	82.2
210402	Тээвэр, шатахуун	15,223,200.00	12,882,540.00	2,340,660.00	84.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,805,200.00	7,579,346.00	3,225,854.00	70.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	569,800.00	-	569,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,633,600.00	496,700.00	1,136,900.00	30.4
2105	<b>Нормативт зардал</b>	2,203,200.00	1,904,600.00	298,600.00	86.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,403,200.00	1,403,200.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	501,400.00	298,600.00	62.7
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	48,940,100.00	57,916,600.00	(8,976,500.00)	118.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,801,000.00	3,240,000.00	6,561,000.00	33.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	4,608,000.00	(1,900,000.00)	170.1
210604	Урсгал засвар	36,430,500.00	50,068,000.00	(13,637,500.00)	137.4
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	8,871,800.00	5,013,900.00	3,857,900.00	56.5
210702	Дотоод албан томилолт	8,871,800.00	5,013,900.00	3,857,900.00	56.5
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,156,100.00	7,439,286.00	5,716,814.00	56.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	4,216,830.00	283,170.00	93.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,282,000.00	-	4,282,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,092,200.00	2,092,200.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	594,000.00	299,756.00	294,244.00	50.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,900.00	77,000.00	209,900.00	26.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,401,000.00	753,500.00	647,500.00	53.8
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,722,800.00	5,811,820.00	12,910,980.00	31.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,639,900.00	5,673,220.00	10,966,680.00	34.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,082,900.00	138,600.00	1,944,300.00	6.7
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,891,571,000.00	1,656,477,205.00	235,093,795.00	87.6
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,891,571,000.00	1,656,477,205.00	235,093,795.00	87.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	578,074,400.00	460,094,649.00	117,979,751.00	79.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,312,896,600.00	1,195,432,556.00	117,464,044.00	91.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	950,000.00	(350,000.00)	158.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,546,713,900.00	2,486,123,900.00	60,590,000.00	97.6
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,542,213,900.00	2,482,213,900.00	60,000,000.00	97.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,542,213,900.00	2,482,213,900.00	60,000,000.00	97.6
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	4,500,000.00	3,910,000.00	590,000.00	86.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	3,910,000.00	590,000.00	86.9
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	33.00	33.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,691,762,394.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,691,762,394.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>319,112,394.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>114,631,130.00</b>
210101	Үндсэн цалин	35,717,147.00
210102	Нэмэгдэл	72,463,983.00
210104	Урамшуулал	6,450,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,523,800.00</b>
210401	Бичиг хэрэг	70,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,453,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>71,060,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,510,500.00
210502	Хоол, хүнс	550,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,140,000.00</b>
210604	Урсгал засвар	2,140,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,469,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,469,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>119,287,964.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,287,964.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,372,650,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,372,650,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,372,650,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,804,780,865.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,804,780,865.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	92,709,245.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,545,607,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	153,513,920.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын / цаашид Эрүүл мэндийн газар гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт, анхан шатны баримтын бүрдэл, хөтлөлт, мөнгөн кассын журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн газрын эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын бие бялдрыг хөгжүүлэх, ажлын үр дүнг дээшлүүлснээр хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэх”-д оршино.

Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах,
- Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах,
- Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих,

- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,570,801.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 35,708.0

мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 24,995.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,754.9 мянган төгрөгөөр буюу 47.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	62,196.3	42,718.5	(19,477.8)
Урьдчилгаа			
Бараа материал	56,397.2	19,120.2	(37,277.0)
Үндсэн хөрөнгө	678,090.9	667,563.8	(10,527.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>796,684.4</b>	<b>729,402.5</b>	<b>(67,281.9)</b>
Өр төлбөр	3,616.0	44,709.7	41,093.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	793,068.4	684,692.8	(108,375.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>796,684.4</b>	<b>729,402.5</b>	<b>(67,281.9)</b>

Авлагын дансны үлдэгдэл 42,718.5 мянган төгрөг болж 19,477.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны татаас санхүүжилтийн 62,196.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан болон ЭМЯ-наас авах албан хаагчдын илүү цагийн хөлс 10,702.8 мянган төгрөг, МЭИК-оос худалдан авсан оношлуурын үнэ 19,617.0 мянган төгрөг, сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэгийн зардлын үлдэгдэл 6,695.9 мянган төгрөг, эмнэлгийн мэргэжилтнүүдэд олгох нэг удаагийн дэмжлэгийн үлдэгдэл 5,000.0 мянган төгрөг, сорьц тээврийн замын зардлын 202.8 мянган төгрөг болон шүүхийн шийдвэрийн дагуу иргэнээс авах 500.0 мянган төгрөг зэрэг нийт 42,718.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,120.2 мянган төгрөг болж 37,277.0 мянган төгрөгөөр буурсан нь ХӨСҮТ-аас 10,173,066.3 мянган төгрөгийн, ЭМЯ-наас 399,485.7 мянган төгрөгийн, ДЭМБ-аас 377,078.6 мянган төгрөгийн нийт 10,949,630.6 мянган төгрөгийн эм боох материал, 3,000.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвийн хөрөнгөөр 176,135.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 11,166,042.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,183,133.0 мянган төгрөг болж өмнөх оноос 68,730.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-наас 24,251.9 мянган

төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, аймгийн ОНХО-аар 9,900.0 мянган төгрөгийн лед дэлгэцийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, төсвийн хөрөнгөөр 23,828.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 4,070.0 мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг аймгийн ИТХТ-ийн тогтоолыг үндэслэн акталсантай холбоотой байна.

4317143998  
МНСА0065 9055436

Өр төлбөр дансны үлдэгдэл 44,709.7 мянган төгрөг болж 41,093.7 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын голомтод ажилласан эмч, эмнэлгийн албан хаагчид олгох цалин, НДШ-ийн зардалд 25,092.7 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн үнэнд 19,617.0 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 684,692.8 мянган төгрөг болж, 108,375.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,457,705.8 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн нь нь Ковид-19 цар тахлын үед холбогдох байгууллагуудаас бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бүртгэл тайланд тусгасантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 11,830,467.6 мянган төгрөгөөр буюу 3.3 дахин өссөн нь нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 1,748,988.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 797,725.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,546,713.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин болон нэмэгдэл урамшлын зардлыг 55,393.7 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 743,839.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталснаас голлон шалтгаалсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,546,713.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,542,213.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,482,213.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 3,910.0 мянган төгрөг, нийт 2,486,123.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **2,254,077.0** мянган төгрөгийг зарцуулан, 232,046.9 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,254,077.0 мянган төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь бараа, үйлчилгээний зардал, хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЭМС-ын 2021 оны А/496, А585 дугаар тушаалаар ковид-19 цар тахлын үед дайчлагдан ажилласан албан хаагчдад 1,546,607.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 12,950.0 мянган төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтний холбооноос үзлэгийн зардалд 20,088.6 мянган төгрөг, ЭМЯ-наас ковид-19 цар тахлын үед дайчлагдан ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлс, дархлаажуулалтын хяналтын зардалд 72,720.8 мянган төгрөг, ковид-19 цар тахлын шинжилгээний төлбөрт 90,217.5 мянган төгрөг, Сангийн яамнаас урьд оны үлдэгдэлд 62,196.3 мянган төгрөг зэрэг нийт 1,804,780.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төвлөрсөн нийт орлогоос ковид-19 халдварын нөхцөлд ажилласан эмч, эмнэлгийн ажилчдад илүү цагийн хөлс, урамшуулал, сорьц тээвэрлэсний хөлс болон төсөл арга хэмжээний урсгал зардалд нийт 1,499,273.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 121,428.0 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 71,060.5 мянган төгрөг зэрэг нийт 1,691,762.4 мянган төгрөгийг зарцуулан, 70,800.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлж, 42,218.5 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар** гэнэ”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1-д “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо

тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно.”, 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл аймгийн Эрүүл мэндийн газрын тэтгэвэр, тэтгэмжийг хянах үүрэг бүхий ажлын хэсгээс ЭМЯ-нд хүргүүлсний дагуу хянаж, дараах албан хаагчдад / төрөөс бусад үйлдвэрийн газарт ажиллаж байсан хугацааг төрд ажилласан хугацаанд тооцож / өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон байна. Үүнд:

1. Мандал сумын Сум дундын нэгдсэн эмнэлгийн бага эмч С.Хандаамаагийн, СББ ХХК, УБТЗ-ийн Зүүнхараа нэгдсэн эмнэлэгт ажиллаж байсан 22 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, нийт 22,028.4 мянган төгрөг,

2. Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн манаач Д.Лханаажавын Сэлэнгэ аймгийн Бараа хангамжийн бааз, Бөөний бараа бааз-д ажиллаж байсан 14 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, нийт 12,152.0 мянган төгрөг,

Эдгээр нь СББ ХХК, УБТЗ-ийн Зүүнхараа нэгдсэн эмнэлэг, Сэлэнгэ аймгийн Бараа хангамжийн бааз, Бөөний бараа бааз зэрэг нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв хянасны үндсэн дээр тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

3.7.2. Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг үндэслэн урсгал засварын батлагдсан төсвөөс эрүүл мэндийн системийн сургалтын төвийг барьж байгуулахад буюу хөрөнгийн зардалд тайлант онд 50,068.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Цаашид хөрөнгийн шинж чанартай зардлыг урсгал зардалд бус холбогдох зардлын эдийн засгийн ангилалд тусган, батлуулж байх шаардлагатай байна.

3.7.3 Тайлант онд ковид 19 цар тахлын шинжилгээний орлогоос нийт 90,217.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн бөгөөд сорьц шинжилгээний бичмэл тайланд 658 иргэн, цахим файлаар 1682 иргэний бүртгэлийг хийсэн байна. Энэ нь шинжилгээ өгсөн иргэдийн тоог үнэн зөв эсэхийг тулган шалгах боломжгүй байдалд хүргэж байна. Цаашид загвар маягтын дагуу сорьц шинжилгээний бичмэл тайланг тогтмол хөтөлж байх шаардлагатай.

3.7.4 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” болсон 127,683.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 61 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа учир цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газар нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс дараах 1 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдсөнийг биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	33,589.1	2	33,589.1	100
Зөвлөмж	3	-	3	-	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>33,589.1</b>	<b>5</b>	<b>33,589.1</b>	<b>100</b>

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 111,341.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 7 зөвлөмж өгсөн.

##### 4.1 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. **Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:**

1.1.1. Илрүүлэлт: Албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”- аар баталгаажуулж, бүртгээгүй байна.

1.1.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4-ыг зөрчиж байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул илүү цагийн хөлсийг “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”- аар баталгаажуулж, бүртгэж байх.

1.2.1 Илрүүлэлт: Харилцагч байгууллагуудын тооцооны үлдэгдлийн баталгааны хуудсыг хавсралт үзүүлэлтүүдээр нэгтгэж гаргаагүй байна.

1.2.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын Тооцооны үлдэгдлийн баталгаа НХМаягт ТМ-3-ыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх ” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид тооцооны үлдэгдлийн баталгааны хуудсыг хавсралт үзүүлэлтүүдээр нэгтгэж гаргаж байх.

1.3.1 Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэр хөтөлж, авто машинуудад хийгдсэн урсгал засварын ажлуудыг бүрэн бүртгээгүй байна.

1.3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 51 дүгээр тогтоолоор баталсан заавал мөрдөх “Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт” MNS 4601-2011 стандартыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцтэй бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид “Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэр”-ийг хөтөлж, урсгал засварын ажлуудыг бүртгэж, тээврийн хэрэгсэл ашиглалтын хяналтыг сайжруулах.

1.4.1 Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэл нь Мянганы сорилын сан болон Онцгой байдлын ерөнхий газрын нэр дээр тус тус улсын бүртгэлд бүртгэлтэй байна.

1.4.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.2-ыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”

батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд тээврийн хэрэгслүүдийг тухайн байгууллагын эзэмшилд шилжүүлэх.

1.5.1. Илрүүлэлт: Тайлант онд 21,124.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.5.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

## 2. Мөнгөн кассын ажиллагааны журамтай холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: 2021 оны 07 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал ковид 19 цар тахлын шинжилгээг авч нийт 90,217.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд 2-15 хоногийн дараа тушаасан байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дэх “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид тухай бүр өөрийн орлогыг харилцах дансанд тушааж, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.

## 3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Агуулахаас тавьж олгосон бөгөөд шууд зардлаар бүртгэх бараа материал болон үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг бараа материалын үлдэгдлээр бүртгэж, тайлагнасан байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” ба УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө” гэсэн заалтуудтай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид бараа материалын үлдэгдлийг зөв ангилан бүртгэх шаардлагатай.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн газар	7	111,341.9	-	-	-	-	-	-	7	111,341.9